



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/192

Сүхбаатар сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.6 "г", Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Урианхай сурын харвааг хөгжүүлэх, харваачдын ур чадварыг дээшлүүлэх, туршлага солилцох, уламжлалт ёс заншил, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Урианхай сурын харваа" аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахыг зөвшөөрсүгэй.

2. "Урианхай сурын харваа" аймгийн аварга шалгаруулах тэмцээний зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

3. Дэмжлэгийн 1.000.000 /нэг сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр срлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.


4. Зардлын тайланг 2019 оны 06 дугаар сарын 15-ны дотор тайлагнахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Энхбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын  
2019 оны 05-р сарын 27... -ны өдрийн  
А/122... тоот захирамжийн хавсралт



Сэлэнгэ аймгийн “Урианхай сурын харваа” аймгийн аварга шалгаруулах

ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Мөнгөн дүн
1	1-р байр	400.000
2	2-р байр	350.000
3	3-р байр	250.000
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>1.000.000</b>

Төсөв гаргасан:

Ц.Отгонтуяа

/НБХ-ийн мэргэжилтэн/